

Ф.Ницше

ХРИСТ ШҮТЛЭГТНИЙ ЭСРЭГ

Орчуулсан Ц.Нямсүрэн

ЭМШУИС

хэсэгчилсэн орчуулга

...Өвчтөнүүдийн бурхан, аалз-бурхан, сүнс-бурхан болох бурханы тухай христийн ойлголт нь газар дэлхий дээр бий болсон хамгийн завхарсан ойлголтын нэг билээ. Тэрээр хувьсан доройтож буй бурханы хэв маягийн хамгийн дорд түвшинг илтгэж мэднэ. Амьдралыг өөрчлөн, түүнийг ямагт *Дэмжихийн* оронд түүнээс *татгалзсанаар* бурхан зөрчилд орсон! Түүний нэрээр амьдрал, байгаль, амьдрах хүсэл зоригт дайн зарлажээ. Бурхан нь “энэ амьдралыг” гүжирдэх, “хойд насны” тухай худал ярих томъёо болсон! Юу ч бишийг бурхан хэмээн шүтэж, юу ч бишийн төлөөх хүсэл зоргийг ариун хэмээн үзжээ!...

...Христийн шашныг зэмлэхдээ би сүсэгтэн олонтой, түүнтэй садан төрөл шашин болох *буддизм*д шударга бус хандмааргүй байна. Хоёулаа үгүйсгэгч, хоёулаа гутранги шашин гэж тооцогддог ч маш чухал шинжээрээ бие биенээсээ ялгардаг. Тэднийг бүх талаар нь харьцуулж чаддаг болсондоо христийн шашныг шүүмжлэгч би Энэтхэгийн эрдэмтдэд талархнам... Буддизм христийн шашнаас зуу дахин бодитой. Асуудлыг бодитойгоор уужуу авч үзэх хандлага түүнд угаас шингэмэл бөгөөд тэрээр хэдэн зуун дамнан үргэлжилсэн философи эрэгцүүллийн үр дүнд үүссэн. Түүнийг үүсэхээс өмнө “бурхан” хэмээх ойлголт хэдийнэ үгүй болжээ. Буддизм бол түүхэн дэх цор ганц жинхэнэ эерэг шашин, энэ нь (хатуу феноменализм байдаг) танин мэдэхүйн онолд нь ч хамаатай. Бодит байдлын үнэнийг бүр мөсөн хүлээн зөвшөөрч, “нүгэлтэй тэмцэхийг” биш, “зовлонтой тэмцэхийг” номложээ. Ёсзүйн ойлголтоор биеэ хуурах явдлыг хойш тавьсанаараа буддизм христийн шашнаас өөрийгөө эрс заагласан:

миний хэлээр бол буддизм нь *сайн, муугийн цаагуур* байдаг... Буддизм физиологийн хоёр нөхцөл дээр суурилж, түүнд гол анхаарлаа хандуулдаг юм. Нэгд, зовлонг мэдрэх нарийн чадвараар илрэх хэт мэдрэмж, хоёрд, ойлголт, учир шалтгааны эрэгцүүллийн дунд дэндүү удаан байсны эцэст хувийн зөн совингоо “бие үгэйн” тухай ойлголтоор дарах хэт сэтгэл... Физиологийн ийм нөхцөл *цөхрөлийг* төрүүлэх агаад үүнийг болиулахын тулд Будда эрүүл ахуйн арга хэмжээ авдаг. Байгальдаа амьдрах, бадарчлах, хоол хүнсээ тааруулах, мацаг барих, согтууруулах ундааг тэвчих, хор шар хөдөлгөж, уур хилэн бадруулах алив цухалдалтай харилцахдаа хянуур байх, юунд ч, өөртөө ч, өрөөл бусдад ч санаа *үл зовних-энэ* бүхэн нь түүний арга хэрэгсэл юм.

Сэтгэл санааг амирлуулан жаргаах бодлуудыг тэжээн тэтгэх, өөр бусдыг нь даран номхотгох арга хэрэгслийг тэрээр олжээ. Буддагийн хувьд эрүүл мэндийг дэмжин тэтгэдэг бүхэн сайн, сайхан юм. *Мөргөл, хатуужлыг* ч хойш тавидаг. Ямарваа хатуу шаардлага, *албадлага* байдаггүй, сүм хийдийн дотор ч (эдгээрээс татгалзах боломж хэзээд бий). Тэдгээр зүйлс өмнө дурдсан хэт мэдрэмжийг л дэвэргэх төдий юм. Ийм шалтгааны улмаас тэрээр *тэрс үзэлтэнтэй* тэмцэх аливаа тэмцлийг сайшаадаггүй. Түүний сургаал өш хонзон, үзэн ядалт, буруу сэтгэл ер нь юуны ч эсрэг чиглэдэггүй (“дайсагналцал нь дайсагналцлыг хэзээ ч төгсгөдөггүй”-энэ бол буддизмын сэтгэл татам бадаг билээ...). Ерөнхийдөө түүний зөв, учир нь тэрхүү цухалдал түүний сувиллын гол зорилгын үүднээс бол эрүүл мэндэд хортой. Сэтгэлийн шаналгаа “бодит байдлыг” хэт үнэлсэнээс (өөрөөр хэлбэл өөрийгөө бага анхаарч, тэнцвэр, “өөрийгөө хичээх үзлээ” алдсанаас) үүсдэгийг тэрээр анзаарч, оюуны хүсэл сонирхолыг *би* рүү эргэн хандуулахын төлөө тэмцсэн. Буддын сургаал өөрийгөө хичээх үзлийг хариуцлага болгон өөрчилсөн бөгөөд сэтгэлийн бүхэл сувилгаа нь “зовлонгоос хэрхэн ангижрах вэ” хэмээх ганц чухал асуултаар тодорхойлогдон зохицуулагддаг (үүгээрээ цэвэр “шинжлэх ухаанч шинжид” дайн зарлаж, өөрийгөө хичээх үзлийг ёс суртахууны сургаалын түвшинд гаргаж тавьсан Афины иргэн Сократыг санагдуулна)...